

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.01.25

Баянцогт

### Нэг. ТӨРИЙН ЗАХИРГАА, ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сумын Засаг даргын Тамгын газарт Чанарын удирдлагын менежмент 9001 стандартыг нэвтрүүлэх ажлыг тайлант сард үргэжлүүлэн Зөвлөх үйлчилгээг сар тутам авч ажиллаж байна.

Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 26 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулж тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүллээ.

Тус суманд өвөлжилт хүндэрч байгаа тул малчид, мал бүхий иргэдэд туслах сайн санааны аяныг зохион байгуулж байна. Тайлант сард тус сумын уугуул иргэн Д.Наранцэцэгийн санаачилгаар Өвөрмонголын өөртөө засах орны Шилийн гол аймгийн Авга хошууны иргэдээс 11,0 сая төгрөгийн хандивын өвс ирсэнийг 60 малчин өрхөд тус бүр 20 боодол өвсийг үнэ төлбөргүй тарааж малчдад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

Тайлант сард хууль эрх зүйн албан бус сургалтыг 4 удаа Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Үндсэн хууль гэсэн сэдвүүдээр зохион байгуулж давхардсан тоогоор 111 иргэнийг хамрууллаа. Сургалт сурталчилгааны ажилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас 66000 төгрөг зарцууллаа. Мөн Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсээс гэмт Орхонтуул сумын гэмт хэрэг зөрчлийн тайлан мэдээ, гарч буй шалтгаан нөхцөлийн талаарх сургалтыг 1-р сарын 18-19-ны зохион байгууллаа.

Тус суманд 2016 онд баригдаж ашиглалтанд хүлээн авсан Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулахаар орон тоо цалин болон эрхлэгч, багшийн ажлын хэрэгцээнд 2 ширхэг компьютер олгож үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. тус төв нь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харъяанд ажиллах юм.

**Санал, өргөдөл, гомдол:** Тайлант сард иргэдээс нийт 3 өргөдөл хүлээн авсанаас малчин өрхийн шилжин суурьших хүсэлт-1, ажил хүссэн-1, бэлчээрийн маргаан шийдвэрлүүлэн-1 өргөдөл ирсэнийг бүртгэж шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллалаа.

**Бичиг хэрэг:** Тайлант сард ирсэн бичиг-51, үүнээс хариутай 19 бичиг ирсэнээс хугацаа хоцорч ирсэн 3 бичиг байна. Явуулсан бичиг-61 байна. Сумын Засаг даргын А захирамж-6, Б захирамж-1, ЗДТГ-н даргын Б тушаал 7 гарсан байна.

**Иргэний бүртгэл:** Энэ сард шинээр 4 хүүхэд төрсөн байна. Нас баралт-1, гэрлэлт-2, эцэг тогтоолт-1 бүртгэгдсэн. Шилжиж явсан-20, шилжиж ирсэн-21 иргэн байна.

**Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын албанд энэ сард сайн дурын даатгалд 35 хүн, эрүүл мэндийн даатгалд-38 хүнийг хамруулж, төвлөрсөн санд ажил олгогч, даатгуулагчаас 01-р сарын 25-ны байдлаар 8572.65 мян(төгрөгний

шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 1125.3мян\төгрөгний хураамжийн орлого орсон байна.

Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт-368 хүнд-105661.74мян\төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт-105хүнд-24154.88мян\төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 25 хүнд-5842.37 мян төгрөг, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр-1 хүнд 377.0 мян төгрөг, цэргийн өндөр насны тэтгэвэрт 2 хүнд-1578.71 нийт 137237.78мян\төгрөгийг тус тус тавьж олгосон.

**Газар зохион байгуулалт:** Тайлант сард иргэнээс ААН рүү шилжүүлэх 1 нэгж талбарын өргөдөл, нэгж талбарын эрх шилжүүлэх 17 өргөдөл тус тус хүлээж авч шийдвэрлээд байна. Мөн 2018 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлууллаа. Өөрийн өмчлөлийн газрынхаа хагасыг өөрийн хүүхэддээ шилжүүлэн өгөх өргөдөл нэг ирсэнийг мэдээллийн санд бүртгэн зургийг бэлтгэж, өмчилсөн газрын гэрчилгээг авах хүсэлтэй иргэдэд кадастрын зураг, хянан баталгааны акт, захирамжийн хуулбар зэрэг материалуудыг 6 иргэнд гаргаж өгсөн байна.

**Хөдөлмөр халамж:**Нийгмийн халамжийн сангийн 01-р сарын халамжийн тэтгэвэрийг 38 хүнд 5211610 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 23 хүнд 1669040 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 7 эхэд 274840 төгрөг, 0-3 насны хүүхэдтэй 64 эхэд 3200000 төгрөг, Насны хишиг 58 иргэнд 4800000 төгрөгийг тус тус олгосон байна. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настны тэтгэмжид шинээр 2 ахмад, Жирэмсэн эхийн тэтгэмжид шинээр 2 эх, 0-18 насны олон хүүхэдтэй өрх толгойлсон эх 3, Насны хишгийн тэтгэмжид 4 иргэнийг тус тус шинээр хамруулж тэтгэвэр, тэтгэмжийг олголоо.

### **Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Энэ сард хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтийн 2017 оны мэдээг гарган гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт, Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендерийн эрх тэгш байлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн биелэлт, Жендерийн эрх тэгш байдлыг хангах хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8 дах заалтын дагуу нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг дээд газарт хүргүүлэн ажиллалаа.

### **Боловсрол:**

**СӨБ:** 1-р сарын хүүхэд өдрийн төлөвлөгөө 80% биелэгдсэн байна. Энэ сарын 03-04-ны өдрүүдэд УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатын санаачилгаар зохион байгуулагдсан “Сургууль хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд Сэлэнгэ аймгийн баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнд хамрагдлаа. 24-р цэцэрлэг нь сургалтын ЦӨМ хөтөлбөрийг байгууллагынхаа онцлогт тулгуурлан хөтөлбөр төлөвлөгөөг шинэчлэн сайжруулж, хуваарын дагуу хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Мөн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, цахим сургалтын сан бүрдүүлэх зорилгоор “Нээлттэй хөгжүүлэх үйл ажиллагаа”-г 01.22-нд багш нарын дунд цахимаар бэлтгэн зохион байгуулж, ололттой болон дутагдалтай талыг дүгнэн ярилцаж, цаашид анхаарах зүйл дээр нь зөвлөн туслав. Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэгийг 2017.01.10-нд цэцэрлэг дээр зохион байгуулж 111 хүүхдийг хамруулж өвчлөлтэй хүүхдэд эмчилгээ хийх ажлыг зохион байгууллаа.

## **Гурав. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2017 оны эцэст сумын дүнгээр 184757 мал тооллогдсоноос тэмээ-403, адуу-13068, үхэр-16977, хонь-88264, ямаа-66045 тооллогдсон байна. Сумын мал хаваржилтын ажил нь 01-р сарын 20-ны байдлаар оны эхний малын 0,08 буюу 148 толгой мал хорогдсоноос адуу 13, үхэр 35, хонь 61, ямаа 50 толгой хорогдоод байна.

Мал төлөлт төл бойжилт одооны байдлаар мал төллөөгүй ба 2018 онд 85975 хээлтэгч төллөнө.

2018 онд тариалалтанд шаардлагатай, тариалах талбай, үр, захиалгыг аж ахуйн нэгж бүрээр авах ажлыг хэрэгжүүллээ. Мөн ТЭДСангаас зээл авсан иргэдтэй холбогдож зээлийн иргэн төлөлтийг барагдуулах ажлыг зохион байгуулан зээлээр бага оврын трактор авсан 8 иргэнтэй холбогдож зээлийн эргэн төлөлтийг барагдуулах ажил хийгдлээ. 2018 онд төв суурин газрын хүн амыг орон нутаг тариалсан цэвэр хүнсний ногоогоор хангах үүднээс хүнсний ногоо тариалдаг тариаланчдад хүлэмжийн аж ахуй эрхэлэх нөхцөл бололцоогоор хангах зорилт тавьж нийт 34 иргэнд хүлэмжийн талаар мэдээлэл өгч ажилсанаас гадна тэдний захиалгыг авч материалыг бүрдүүлээд байна.

Аж ахуйн нэгж иргэдээс авсан мэдээллээр 2018 онд 15566 га-д тариалалт хийхээр төлөвлөж 1441,2 тн улаан буудайн үрийн захиалгыг аж ахуйн нэгж, иргэд өгөөд байна.

2017 онд улсын үйлдвэрийн газарт арьс шир тушаасан арьс ширний урамшуулалын 215 хүний 605 ш падааныг программд шивж оруулан аймгийн ХАА-н газарт хүргүүлээ. Сум малчид тариаланчид, ногоочид, уяачдын ажлын үзүүлэлт гарган Улсын “Аварга малчин”-д 1 хүний, “Тэргүүний тариаланч”-д 1 хүний ажлын үзүүлэлт ажил байдлын тодорхойлолтыг гарган улсад, нэг малчин нэг ногоочин 4 уяачын ажлын үзүүлэлт ажил байдлын тодорхойлолтыг гарган сумын ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн ҮХАА-н газарт материалуудыг нь хүргүүлэн ажиллалаа.

2018 оны өвөл цагаан зудын байдалтай байгаа тул аймгийн нөөцөөс олгосон 2000 кг минралны тэжээлийг Баянгол сумаас татаж төвлөрүүлээд байна.

## **Дөрөв.СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Сумын Соёлын төв нь тайлант сард нийт 300 гаруй иргэнийг хамруулсан 3 үйл ажиллагаа зохион байгуулсан байна. Мөн Нийтийн номын сангаар 224 уншигч ирэгсэдийг хүлээн авч үйлчилсэн байна. Соёлын төвд Бүжгийн дугуйлан тогтмол ажиллаж энэ сард 24 иргэн дугуйланд хамрагдсан байна.

Мэдээ бичсэн:

ТЗХЭЗ дотоод ажил  
хариуцсан мэргэжилтэн

\ Д.Мэнд-Амар \

Хянасан:

ЗДТГ-ын дарга

\ Ш.Өнөрбаяр \

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 02 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.02.24

Баянцогт

### Нэг. Төрийн захиргааны чиглэлээр:

Тайлант сард тус сумын Засаг даргын Тамгын газар нь иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цаг хугацаанд нь хурдан шуурхай үзүүлж ажилласны дээр сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 хэрэгжилт, үр дүнг иргэдэд тайлагнах ажлыг зохион байгууллаа.

Сумын хэмжээнд өвөлжилт хүндэрч байгаа тул зам даваа хаагдсан газруудад өвөлжиж байгаа малчдын хотонд хүрч, амьдрал ахуйтай газар дээр танилцаж, төрийн үйлчилгээг хүргэж тэдний санал хүсэлтийг сонсох малчдын сэтгэл санааг дэмжих зорилгоор сумын ИТХ-н дарга М.Цогбаяр, Засаг дарга П.Батбаатар, Засаг даргын орлогч П.Отгонбаяр, ЗДТГ-н дарга Ш.Өнөрбаяр нараар ахлуулсан 4 ажлын хэсэг дөрвөн чиглэлд хөдөө явж ажилласан бөгөөд мөн энэ үеээрээ аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газраас ирүүлсэн тусламжийн зүйлсийг малчдад гардуулан өгсөн байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргил тус сумын өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, малчид иргэдтэй уулзалт хийж, аймгийн нөөцөөс өвс, тэжээлийн тусламж үзүүллээ.

Сар шинийн баярыг угтан уламжлал ёсоор аймаг, сумын Сайн малчин, Алдарт уяачдын материалыг бүрдүүлэн дээд шатны байгууллагуудад хүргүүлэхээс гадна сумын Сайн малчин, Алдарт уяач тодруулан шагнаж урамшууллаа. Сумын “Сайн малчин”-аар Баянцогт 2-р багийн малчин Л.Бат-Отгон, Хонгор-Овоо 3-р багийн малчин Н.Содномпил, сумын “Алдарт уяач”-аар Шар-Ус 1-р баг, Рашаант тосгоны иргэн Н.Мягмаржав нар нь сумын Шагналын болзол журмын хангасан тул энгэрийн тэмдэг, өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа. Сумын сайн малчин, алдарт уяачийн шагналд зарцуулах 300,000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулсан байна.

**Нийгмийн халамж:** Нийгмийн халамжийн сангийн 01-02-р сарын халамжийн тэтгэвэрийг 41 хүнд 11957740 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 23 хүнд 3099040 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 8 эхэд 556270 төгрөг, 0-3 насны хүүхэдтэй 74 эхэд 8319470 төгрөг, 0-18 насны хүүхэдтэй 2 эхэд 480000, Алдарт эхийн 1-р одонтой 47 эхэд 9400000, 2-р одонтой 127 эхэд 12700000 төгрөг, Насны хишиг 58 иргэнд 6730000 төгрөгийг тус тус олгосон байна. Алдар цолтой 5 ахмад настанд тусламж 1600000 төгрөг олголоо. Жирэмсэн эхийн тэтгэмжид шинээр 10 эх, 0-18 насны олон хүүхэдтэй өрх толгойлсон 3 эх, Насны хишгийн тэтгэмжид шинээр 4 иргэнийг тус тус шинээр хамруулж тэтгэвэр, тэтгэмжийг олголоо. Насны хишиг авах 58 иргэний 2018 оны бичиг баримтын баяжилт хийж, программд шивж, тэтгэмжийг олгосон байна. Алдарт эхийн одонтой 174 эхийн хувийн хэргийн баяжилт хийж, программд шивж одонгийн мөнгийг олгож дуусгасан байна.

МУЗГ-ын 2017 оны 12-р сарын 13 ны өдрийн 340-р тогтоолын дагуу 2018 оны 1-р сарын 1-нээс эхлэн олгох 0-3 насны хүүхэдтэй 74 эхийн материалыг хүлээн авч хувийн хэрэг нээж хянуулан, тэтгэмжийг олгоод байна.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй байсан 3 өрхийг судалгаанд хамруулж түвшинг нь тогтоолголоо.

### Хоёр. Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2017 оны эцэст сумын дүнгээр 184757 мал тооллогдсоноос тэмээ-403, адуу-13068, үхэр-16977, хонь-88264, ямаа-66045 тоологдсон.

Сумын мал хаваржилтын ажил нь 02-р сарын 23-ны байдлаар оны эхний малын 0,7% буюу 1367 толгой мал хорогдсоноос адуу 42 үхэр 280 хонь 529 ямаа 516 хорогдсон. 2018 онд 85975 хээлтэгч төллөхөөс мал төллөлт төл бойжилт одоогийн байдлаар 1287 толгой мал төллөж гарсан төлийн 99,5% бойжиж байна. 2018 онд 85975 хээлтэгч төллөнө. Цас зудын улмаас малын тарга хүч муудах, хэвтэрт орох, хээл хаях зэрэг сөрөг үр дагвар гарч байгааг харгалзан малчид иргэдэд зөвлөмж өгөх урьдчилан сэргийлэх талаар анхааран ажиллаж байна.

2018 оны өвөл цагаан зудын байдалтай байгаа тул аймгийн нөөцөөс олгосон 2000 кг минралны тэжээлийг Баруунхараагаас авчирж малчдад тараалаа. Түүнчлэн улсын нөөцөөс 4000 боодол өвс, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатаас 2000 боодол өвс, мөн 8000 шуудай тэжээлийг Дархан уул аймгийн Хонгор сумаас татаж малчид иргэдэд хуваарилан олгоод байна.

Мэдээ бичсэн:

ТЗХЭЗ дотоод ажил  
хариуцсан мэргэжилтэн

\ Д.Мэнд-Амар \

Хянасан:

ЗДТГ-ын дарга

\ Ш.Өнөрбаяр \

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 03 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2018.03.25

Баянцогт

### Нэг. Төрийн захиргааны чиглэлээр:

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэж ажиллалаа.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас цахим тендерийн тухай сургалтыг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хамруулан 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан сумын Засаг даргын Тамгын газарт Олон улсын чанарын удирдлагын iso 9001 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд энэ сарын 01,02-нд 5 дахь удаагийн зөвлөх үйлчилгээг авч ажиллалаа.

Сумын Удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг жил бүрийн 1-р улиралд зохион байгуулан ажилладаг байсныг энэ онд сумын Төрийн албан хаагчдын анхдугаар зөвлөгөөн болгон 03 дугаар сарын 05-ны өдөр өргөн хүрээнд зохион байгуулан 2018 оны Сахилга хариуцлагыг өндөржүүлж-хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх ажил болгох зорилт тавьж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн тус зөвлөгөөнөөс “Төрийн албан хаагч бүр: Төрийн албаны чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд 2018 онд “Сахилга хариуцлагыг өндөржүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлнэ” зорилтыг өөрийн ажлын байранд хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй хүргэж, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, харилцааны соёлыг эрхэмлэн төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөн ажиллана. гэсэн уриалгыг гаргасан байна.

**Цэрэг, иргэний хамгаалал:** Цэргийн тоо бүртгэлийг сүүлийн 5 жилээр гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабд хүргүүлээ.

**Хууль эрх зүйн албан бус сургалтын үйл ажиллагаа:** Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд тайлант сард “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”, “Эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай хууль” сэдвүүдээр сургалт, Татварын хуулийн шинэлчлэл, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчлэлээр иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж, “Монгол цэргийн өдөр”-г тохиолдуулан Ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурагчдын дунд “Цэргийн жавхаа” АСТ-н зохион байгууллаа. Сургалт сурталчилгааны ажилд төсвөөс 80,000 төгрөг зарцууллаа.

**Бичиг хэрэг, архивын үйл ажиллагаа:** Энэ сард Засаг даргын захирамж-5, Тамгын газрын даргын боловсон хүчинтэй холбоотой-2 тушаал гарсан байна. Засаг даргын Тамгын газарт Цахим болон шуудангаар нийт 39 бичиг ирсэнээс хариутай 13 бичиг, хугацаа хоцорч ирсэн 1 бичиг байна. ЗДТГ-аас 11 бичиг явуулсан байна. Архивын лавлагаа авахаар ирсэн нийт 2 иргэнд шаардлагатай байгаа материалыг шүүж өгч ажиллалаа. Мөн сумын Архивт хадгалагдаж байгаа татан буугдсан Сангийн аж ахуй, Дулааны станц, “Орхон булаг”ХК, Хөгжил нэгдэл зэрэг газруудын тушаал,

цалингийн хүснэгт болон 2007-2010 оны сумын Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал зэрэг байнга хадгалах нэгжийг аймгийн Төрийн архивт шилжүүлэх ажлыг зохион байгууллаа.

**Иргэний бүртгэл:** Энэ сард шинээр 2 хүүхэд төрсөн байна. Гэрлэлт-3, Нас баралт-1, эцэг тогтоолт-1 бүртгэгдсэн. Шилжиж явсан-19, шилжиж ирсэн-21 иргэн байна. 2016-2020 оны сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам"-ыг хэрэгжүүлэн шинэ төрсөн 2 хүүхдэд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгууллаа.

**Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын албанд энэ сард сайн дурын даатгалд шинээр 5 хүн, эрүүл мэндийн даатгалд- 34 хүнийг хамруулж гэрээ байгуулан дэвтэрт нь баталгаажуулалт хийлээ.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч, даатгуулагчаас 03-р сарын 22-ны байдлаар 15418,4 мян төгрөгний шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 1520,4 мян төгрөгний хураамжийн орлого 02-р сарын 22-ны байдлаар орсон байна.

Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт - 366 хүнд-115447.9 мян\төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт-125 хүнд- 33689,5 мян\төгрөг тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 23 хүнд-6587.0 мян\төгрөг, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр -1 хүнд 404.5 мян\төгрөг цэргийн өндөр насны тэтгэвэрт-1632,7 нийт 157761,6 мян\төгрөгийг тус тус тавьж олгосон.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж-2 хүнд 84.1, жирэмсэн амаржсаны тэтгэвэр 3-хүнд-1747,2 мян\төгрөг, оршуулгын тэтгэмж 1 хүнд-1000.0 ажилгүйдлийн тэтгэмж 2 хүнд-440,9 мян\төг нийт тэтгэмжинд 3272,2 мян\төгрөгийг хугацаанд нь олгосон байна. Шинээр өндөр насны тэтгэвэрт-1 тахир дутуу тэтгэвэрт-1 хүний материалыг хүлээн авч хянуулан тэтгэврийг хугацаанд нь олголоо.

### **Хоёр. Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

2017 оны эцэст тэмээ-403 толгой, адуу-13068 толгой, үхэр-16977 толгой, хонь-88264 толгой, ямаа-66045 толгой буюу нийт 184757 толгой мал өвөлжиж, хаваржиж байна. Оны эхний 3 сарын байдлаар сумын хэмжээнд нийт малын 1,2% буюу 2246 мал хорогдсоноос тэмээ-2, адуу-62, үхэр-43,8 хонь-838, ямаа-906 хорогдсоноос өвчнөөр 135 толгой мал хорогдсон байна.

Төллөх 85975 толгой малаас 6992 толгой хээлтэгч төллөж мал төллөлт 8,1%-тай гарсан төлийн 97,9% буюу 6849 толгой төл бойжиж байна. Үүнээс ингэ-16, гүү-86, үнээ-251, эм хонь-4551, эм ямаа-2088 төллөж байна. Цаашид мал төллөлт эрчимтэй явагдаж өвөл, хаврын улиралд ядарсан хээлтэй мал хээлтэх, том мал болон төлийн хорогдол их гарах төлөвтэй байна. Малын зүй бус хорогдол, төллөлтийн мэдээг аймгийн ХАА-н газарт 7 хоног бүр, УЦУ-ын албанд 10 хоног тутам зохих мэдээнүүдийг өгч ажиллаж байна.

Хил залгаа байгаа бусад аймаг суманд малын гоц халдварт өвчин гарч байгаатай холбогдуулан малчид иргэдэд сэрэмжүүлэг мэдээлэл хүргэх өвчний илрэх шинж тэмдгийн талаар гарын авлага материал тараах, малын шилжилт хөдөлгөөн, хариулга маллагаанд онцгой анхаарч ажиллах талаар зохих зөвлөмжийг өгч ажиллалаа.

### **Гурав. Нийгмийн бодлогын чиглэлээр:**

#### **Боловсролын талаар:**

**СӨБ:**

3-р сарын хүүхэд өдрийн төлөвлөгөө

Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
24-р цэцэрлэг	2709	2038	75%

**Хүүхэд хөгжүүлэх ажлын талаар:** Энэ сард хүүхэд хөгжүүлэх чиглэлээр “Бяцхан цэрэг” уралдаан, “Хуурнин шуугиагч” 4-5 насны хүүхдийн дунд бөхийн барилдаан, “Дуулиан-2018” спорт тэмцээн зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Мөн хүүхэд хөгжүүлэх ажлын хүрээнд “Шүд гар угаах аян” болон “Зөв хооллолт-таны хүүхдийн хөгжилд” сэдэвт үзүүлэх сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөгдсөн байна.

Багш ажилчид болон эцэг эх олон нийтийн дунд сургалтын орчин сайжруулах, тохижуулах ажлын хүрээнд 03-р сарын 16-ны өдөр бүлгийн багш нар өөрсдийн хийсэн бүтээлээрээ эцэг эх олон нийтэд бүтээлийн үзэсгэлэн гаргалаа. Аймгийн МХГ-ын Боловсрол хариуцсан улсын байцаагч Цогтгэрэл, ЭА-н улсын байцаагч Сэлэнгэмөрөн нар цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж “Бага эрсдэлтэй” гэсэн үнэлгээг авлаа.

Мэдээ бичсэн:

ТЗХЭЗ дотоод ажил  
хариуцсан мэргэжилтэн

\ Д.Мэнд-Амар \

Хянасан:

ЗДТГ-ын дарга

\ Ш.Өнөрбаяр \

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 05 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.05.25

Баянцогт

### **НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан сумын Засаг даргын Тамгын газарт Чанарын удирдлагын менежмент 9001 стандартыг нэвтрүүлж төрийн үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор Монголын чанарын удирдлагын зөвлөхүүдийн холбоотой гэрээ байгуулан ажиллаж байна. Чанарын стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газарт хөтлөгдөж байгаа бичиг баримтуудыг нэг загвартай болгох болон бичиг баримтаа эмх цэгцтэй байлгах үүднээс хавтасжуулах, ажлын бүтээмжээ байнга сайжруулах “5s” сургалтыг зохион байгуулаад байна. Мөн иргэдэд төрийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор өрөөний бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт оруулж иргэд хамгийн их үйлчилгээ авдаг Нэг цонхны үйлчилгээг 1 давхарт байрлуулах болон мэргэжилтнүүдийн ажлаа тайлагнах чадварыг сайжруулах зорилгоор Тамгын газрын даргын тушаал гаргаж 7 хоног бүр 1 мэргэжилтэн хамт олондоо хийсэн ажлаа танилцуулж байхыг хэвшүүлэн ажиллаж байна.

Тус суманд 2016 онд баригдаж ашиглалтанд хүлээн авсан Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулахаар 4,5 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах асуудлыг шийдвэрлэж, орон тоо цалин болон эрхлэгч, багшийн ажлын хэрэгцээнд 2 ширхэг компьютер олголоо. Тус төв нь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харъяанд ажиллах юм.

Сумын ИТХ-н 11 дүгээр хуралдаанаар төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр “Төрийн албан хаагчийн сургалт, солилцоо” дэд хөтөлбөр, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” гэсэн 2 хөтөлбөрийн төслийг боловсруулсан батлууллаа.

Сумын Архивт хадгалах хугацаа дууссан болон татан буугдсан байгууллагуудын 1998-2010 оны нийт 138 ширхэг баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийж аймгийн Төрийн архивт хүлээлгэж өгөх ажлыг тайлант хугацаанд зохион байгууллаа.

### **ХОЁР. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

**Хөдөө аж ахуй:** Эхний 5 сарын байдлаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боомын вакцин-8650 үхэрт, дуутын вакцин-4100 толгойд, шөвөг яр - 14500 толгой төлд, гахайн мялзан-300 толгойд тус тус хийж 2018 онд мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний гэрээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Празиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд туулгалт - 47400 бог, 14900 бодод, боловсруулалт - 6650 толгой бодод, 38700 толгой богт хийснээс гадна хонины цэцэг өвчний вакцинийг сумын бүх хонинд хийхээр төлөвлөн ажиллаж байна.

2018 онд улсын хэмээнд малын гоц халдварт шүлхий өвчин гарсан тул вакцинжуулах ажил хийгдэж одоогоор сумын 440 өрхийн 15865 үхрийг шүлхий өвчний эсрэг вакцинаар тарих ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 97,2%-тай хийгдээд байна. 182400 толгой малыг угаалганд хамруулахаар ажиллаж байна.

Сумын нутаг дэвсгэрт өнгөрсөн өвөл цас их хэмжээгээр орж, шуурснаас болж өвөлжилтийн байдал хүндэрсэн энэ хүнд цаг үед тус сумын ЗДТГ-ын санаачлагаар

малчин, мал бүхий иргэддээ нийт давхацсан тоогоор 549 малчин өрх буюу сумын хэмжээнд байгаа малчин, мал бүхий иргэдийн 80% нь хамрагдсан байна.

Тайлангийн хугацаанд суманд үйл ажиллагаа явуулж байгаа Мал эмнэлгүүдийн ажил, үйлчилгээнд тогтмол хяналт тавин ажиллаж, хийсэн ажлын тайланг хэлэлцэн үйлчилгээний хөлсийг олгох болсон нь мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж байна.

Манай сум нь Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж байгаа БАХ \Бэлчээр ашиглах хэсэг байгуулах “Ногоон алт” хөтөлбөрт хамрагдсан тул сум орон нутагт уг ажлыг зохион байгуулан бэлчээрийн хүртээжийг сайжруулах ажлыг хэрэгжүүлэхээр малчдын саналд тулгуурлан сургалт сурталчилгааны ажлыг хийж одоогийн байдлаар бэлчээр ашиглалтын хоёр хэсэг үйл ажиллагаандаа ороод байна. Үүнд “Чулуут баялаг” БАХ, “Ихэр гацаа” БАХ тус тус байгуулагдан цаашдын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллахаар хэсгийн хурлыг зохион байгуулаад байна. Цаашид БАХ-г байгуулах саналыг 6 хэсэг дэвшүүлээд байна. Уг ажлыг ойрын хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2018 онд Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс “Эрчимжсэн үхрийн аж ахуй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс сайн үүлдрийн бух нийлүүлэх ажлын хүрээнд суманд 20 бух авахаар захиалгаа хүргүүлээд байна. Өнөөдрийн байдлаар тус суманд цэвэр эрлийз үүлдрийн Сэлэнгэ үхэр-13460, Алатау үүлдрийн үхэр-68, Хар тарлан үүлдрийн үхэр-26, Герефорд үүлдрийн үхэр-8 толгой байна. Энэ нь нийт үхрийн 69,5%-ийг эзэлж байна. Цэвэр эрлийз үхрийн 99,2% Сэлэнгэ үүлдэр 0,6% Алатау 0,2%-ийг хар тарлан үүлдрийн үхэр эзэлж байна. Энэ онд суманд үржүүлж байгаа үхэр сүргийн үүлдэрлэг байдал түүний ашиг шимийн гарцыг тогтоох ажлыг хийж эхлээд байна. Үүнд: ямааны ноолуурын гарц 2018 онд нийлээд сайн нэг ямаанаас 325 гр ноолуур авсан дүнтэй байна. Малын чанар ашиг шимийг нь сайжруулах, Сэлэнгэ үүлдрийн үхрийн генфондыг хамгаалах чанарыг сайжруулах зорилгоор үхэрт зохиомол хээлтүүлэг хийх ажлыг хэрэгжүүлэн ажилсанаар гарсан тугалын амьдын жин нутгийн үхрийн тугалын жингээс даруй 4-6 кг-аар илүү байгаа нь цаашид уг ажлыг хэрэгжүүлэн олон тооны малыг хамруулах шаардлага тулгарч байна. Мөн малчид иргэдийн үндэсний үйлдвэрт тушаасан ноос, арьс ширний падааныг авч тусгай программд шивж холбогдох газруудад хүргүүлэн ажилсан.

Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор нийт 425 малчны 472 ш ноосны падааныг, 251 малчны 605 ш арьс ширний падааныг хүлээн авч холбогдох газарт хүргүүлэн дээрх малчид иргэдийг улсын үйлдвэрт тушаасан бүтээгдэхүүний урамшуулалд хамрагдах нөхцөлөөр ханган ажиллалаа.

**Газар тариалан:** 05-р сарын 30-ны байдлаар улаан буудай-7800 га-д, рапс-1500 га-д, эрдэнэ шиш-50 га-д, цагаан будаа-4 га-д, төмс-7,0 га-д, хүнсний ногоо-20,9 га-д тус тус тариалаад байна. ТЭДСангийнГазар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх гол түүхий эд болох ургамал хамгааллын бодис бордоог урьдчилгаанөхцөлтэйгээр намар бүтээгдэхүүнээрээ төлөх гэрээгээр нийлүүлэн хийх 17 иргэн 18 ААН-тэй хамтран ажилласан байна. Мөн ТЭДСангийн хөнгөлөлттэй, урьдчилгаатай 6х20 хэмжээтэй хүлэмжийг зээлээр 5 иргэн авч өмнөх 2017 онд 11 хүлэмжинд тариалж байсан бол 2018 онд 45% хувиар хүлэмжийн тариалалт нэмэгдсэн нь хүнсний ногооны тариалалтын нэр төрөл олшрох га-аас авах ургац нэмэгдэх нөхцөл бүрдлээ.

**Хөрөнгө оруулалт:** Энэ онд улс, аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Рашаант тосгонд 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сумын Халаалтын төвийн тогоо шинэчлэх, 24-р цэцэрлэгийн дээвэр, хаалганы засвар, сумын Эрүүл

мэндийн төвийн морг, гражийн засвар, Рашаант тосгонд Сүү хөргүүрийн танк худалдан авах, Рашаант тосгоны зам засвар, сумын төвд жишиг хороолол, Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах, Зөөврийн эхо аппарат худалдан авах зэрэг томоохон хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэхээр батлагдсан. Эдгээр ажлуудаас Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах 13,0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй ажил, Рашаант тосгон зам засвар 20,0, 24-р цэцэрлэгийн дээвэр засвар 53,0 сая төгрөгийг төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулаад байна. Мөн гатлага онгоц бирваз нь цоорч ус орж ажиллах боломжгүй байсныг 1,5 сая төгрөг гаргаж Засаг даргын Тамгын газрын ажилчдын хүчээр засч ажиллах боломжтой болголоо.

Сумын ЗДТГ, Соёлын төвийн барилгын дээвэр засвар, Соёлын төвийн сантехникийн засвар ажлууд аймгийн хөрөнгө оруулалтаар "Есөнхэлхээ"ХХК гүйцэтгэж гэрээнд заагдсаны дагуу хугацаандаа хүлээлгэн өгсөн байна. Мөн Рашаант Эрүүл мэндийн төвд түргэн тусламжийн машины парк шинэчлэлт хийгдлээ.

### **ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

**Хүн ам, шилжилт хөдөлгөөн:** Оны эхний 5 сарын байдлаар Шинэ төрсөн-25 хүүхэд, эцэг тогтоолт- 10, Гэрлэлт -9, Нас барсан-8, шилжиж ирсэн-74, шилжиж явсан-70 иргэн байна.

“Шинэ төрсөн хүүхэд,эх”-д хүндэтгэл үзүүлэх журам”-ын дагуу 25эх, хүүхдэд хүндэтгэл үзүүлж баталсан төсвөөс 500,000 төгрөг зарцуулсан байна.

**Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын төвлөрсөн санд 5-р сарын байдлаар ажил олгогч даатгуулагчаас 148745,4мянган төгрөгний шимтгэлийн орлогыг төвлөрсөн санд оруулж төлөвлөөг 94,8 хувьтай биелүүлэн ажилласан.

Сайн дурын даатгалд 2018 онд шинээр 40 даатгуулагч, нийт 163 даатгуулагчаас 34956,6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд малчин -118, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн -78, оюутан-20 нийт 216 даатгуулагч хамрагдаж 9343,7 мянган төгрөгний орлого оруулж ажиллалаа.

**Боловсрол:** Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг 5 бүлэг 21 багш, ажилчдын орон тоотой, орон нутгийнхаа өөрийн тойргийн 130 хүүхэд, малчдын 39 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох, сургалт хүмүүжил, хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан ажиллаж байна. Сумын хэмжээний хамран сургалт 93 хувьтай байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, зуны цэцэрлэгийг орон нутагт ажиллуулах, малчдын хүүхдийг сургуульд элсэн суралцах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд 2-5 насны малчдын хүүхдийн судалгааг урьдчилан гаргаж Шар-Ус болон Ар булагт сургуулийн өмнөх боловсролыг 2-5 насны хүүхдүүдэд зуны хувилбарт сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.

**Ерөнхий боловсрол:** Сумын хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд нийт 590 хүүхэд суралцаж байна.

2017-2018 оны хичээлийн жилд 1-р сургууль дээр 5 төрлийн секц, дугуйланд давхардсан тоогоор 175 хүүхэд хамрагдаж сурагчдын 64.8% нь өөрийгөө хөгжүүлэх дугуйлан, секцэнд 2-р сургууль дээр 7 төрлийн секц, дугуйланд давхардсан тоогоор 173 сурагч хамрагдаж байна. ЕБ 1-р сургууль дээр шинээр банзан гитарын дугуйлан 4-р улирлаас эхлэн хичээллэж 12 сурагч хамрагдаж байна.

ЕБ1-р сургуульд 2017-2018 оны хичээлийн жилд “Steam”-сургалтын хэрэглэгдэхүүн хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх тоглоом болон бусад

хэрэглэгдэхүүн, ширээ сандал, номын тавиур зэрэг нийт 7.900.000 төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. 2018 оны 04-р сард УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатын хэрэгжүүлж буй сургуулийн хөгжил хөтөлбөрийн хүрээнд “Гитар”-төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийт 6ш гитартай болсон.

ЕБ2-р сургуульд тайлангийн хугацаанд нийт 12,671,000 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Аймгийн БСУГ-с санхүүжүүлсэн бага боловсролын сурагчдын STEM сургалтын хэрэглэгдэхүүн-4,171,100 төгрөг, аймгийн БСУГ-аас суралцагчдын хувцасны шкаб 15 ширхэг-420000 төгрөг, хүндэтгэлийн шилэн тавиур-550,000 төгрөг, Номын шкаб-450000 төгрөг, ширээ-800000 төгрөг нийт 6,000,000 төгрөг, “Орхон хөгжил”ХХК-иас Үдийн цайны гал тогооны тоног төхөөрөмж 2,500,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

2017-2018 оны хичээлийн жилд үдийн цай хөтөлбөрт сумын хэмжээнд нийт 312 сурагч хамрагдаж байна.

**Эрүүл мэнд:** Тайлангийн хугацаанд эх, хүүхдийн эндэгдэлгүй ажиллаж байна. Сумын хэмжээнд 23 жирэмсэн эх хяналтанд байгаагаас Рашаант Эрүүл мэндийн төвд эмнэлэгт 5 эх төрсөн байна. Сумын эмнэлгүүд нь өндөр настан болон хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нярайг сар бүр гэрээр үзэж сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Эх хүүхдийн гэрийн эргэлтийг тогтмолжуулан 0-5 насны хүүхдийн өсөлтийг сар бүр айл өрхүүдээр явж хэмжилт хийн витаминжуулалт болон вакцинд бүрэн хамруулсан. Үүнд: нийт давхардсан тоогоор 1054 хүүхдийн өсөлтийг хэмжин, жинлэж, 326 хүүхдэд А амин дэм уулгаж, Олон найрлагат нэмэлт бичил тэжээлийн бэлдмэлийг давхардсан тоогоор 103 хүүхдэд уулгаж бугалагны тойрог өндөр жинг сар болгон үзэж хэмжилт хийсэн байна.

Эхний 6 сарын байдлаар Рашаант Эрүүл мэндийн төвд сүрьеэ өвчин 2 илэрсэнээс шинээр илрүүлсэн-1, дахисан сүрьеэ-1 гарсаныг хяналтанд авч үргэлжлэх шатны эмчилгээгээ хийлгэж байна. Сумын Эрүүл мэндийн төвд сүрьеэгийн өвчлөл байхгүй.

Тайлангийн хугацаанд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаанд 300 гаруй иргэнийг хамруулан ажилласан байна.

МЭДЭЭ БИЧСЭН:

ТЭХЭЗ ДОТООД АЖИЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.МЭНД-АМАР

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Ш.ӨНӨРБАЯР

## **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.06.25

Баянцогт

Тайлант сард сумын Засаг даргын Тамгын газраас хууль тогтоомж, хөтөлбөр журам, Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд:

### **НЭГ.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Сумын Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэж тайлант сард иргэдээс ямар нэгэн санал гомдолгүй ажилласан байна.

Иргэдэд хүргэх үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор Чанарын удирдлагын ISO9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын ажлын бүтээмж цаг ашиглалтыг сайжруулж мэргэжилтэн бүрт 10 ширхэг хавтас авч бичиг баримтын эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллалаа. Энэ ажилд төсвөөс 700,000 төгрөг зарцуулсан байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 6-р сарын 1-ний өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Хүүхдийн баярын арга хэмжээний хүрээнд сурлага, урлаг, спортын тэргүүний сурагчдыг шагнаж урамшуулахын дээр байгууллага бүр хүүхэд багачуудыг хөгжөөн баясгах чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаануудыг зохион байгууллаа. Сумын Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Зайрмагны баяр” арга хэмжээ болон бусад үйл ажиллагаанд нийт 380,000 төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Мөн Хүүхдийн баярын өдрөөр Алдарт эхийн одонгоор шагнагдах 13 ээжийн одонг гардуулж сумын Эмэгтэйчүүдийн холбооноос санаачлан зохион байгуулсан “Дархан бэр” арга хэмжээнд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих ажиллах сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд “Сурын холбоо”, “Шагайн холбоо”-ны баг тамирчдыг улс, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын бэлтгэл ажлыг хангаж байгууллагын дарга нарын тушаал шийдвэрийг гаргуулан аймгийн Төрийн сангийн хэлтэст хүргүүлээ.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг сумын Засаг даргын 2018.06.06-ны өдрийн А\71 тоот захирамж гарган төр, төсвийн байгууллагуудад хүргүүлэх хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бичил уурхайн дээвэр холбооноос Тамгын газрын ажилтнууд болон бичил уурхай эрхлэгч иргэдэд бичил уурхайн чиглэлээр гарсан хууль тогтоомж, дүрэм журмыг танилцуулах сургалтыг 06-р сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Энэ оны хагас жилийн байдлаар тус суманд хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэн, үйл ажиллагаа явуулж байгаа сүм, хийдийн мэдээг гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлээ. Тус суманд өнөөдрийн байдлаар

Рашаант тосгонд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Шидэт хөрс”ХХК БНХАУ-н харъяат 3 иргэнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.

**СӨГ:** Тайлант сард иргэдээс нийт 4 өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнд: Малчин өрхийн шилжин суурьших хүсэлт-1, ажил хүсэх тухай-1, мөнгөн тусламж хүссэн-1, бусад-1 байна. Тус суманд шилжиж оршин суух хүсэлт гаргасан малчин Б.Энхтөрийн хүсэлтийг багийн Засаг даргад хариуцуулан судалж шийдвэрлэх, ажлын байр хүссэн иргэнийг Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил хайгчаар бүртгэх, мөнгөн тусламж хүссэн Шар-Ус 1-р багийн иргэн П.Ариунтуяад мөнгөн тусламж үзүүлэх боломжгүй гэсэн шийдвэрийг бичгээр хариу мэдэгдлээ.

**Иргэний бүртгэл:** Энэ сард 6 хүүхэд мэндэлсэн байна. Мөн эцэг тогтоолт-2, Гэрлэлт-1, Нас баралт-1 бүртгэгдсэн байна. Шилжиж явсан-23, шилжиж ирсэн-12 иргэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлэн шинэ төрсөн 6 хүүхэд хүндэтгэл үзүүлж Засаг даргын нөөц хөрөнгөөс 120,000 төгрөг зарцуулсан байна.

**Хөдөлмөр, халамж:** Энэ оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн халамжийн сангийн Халамжийн тэтгэвэрийг 42 хүнд 37661,9 мян/төгрөг, Нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 36 хүнд 9409,0 мян/төгрөг, Жирэмсний тэтгэмжийг 22 эхэд 2868,6 мян/ төгрөг, 0-3 насны хүүхэдтэй 89 эхэд 21790,0 мян/ төгрөг, 0-18 насны хүүхэдтэй 2 эхэд 480,0 мян/ төгрөг, Алдарт эхийн 1-р одонтой 48 эхэд 9600,0 мян/ төгрөг, 2-р одонтой 129 эхэд 12900,0 мян/ төгрөг төгрөг, Насны хишиг 59 иргэнд 4850,0 мян/ төгрөг, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 2 иргэнд 2400,0 мян/төгрөгийг тус тус олгосон байна. Алдар цолтой 5 ахмад настанд тусламж 4800000 төгрөг олголоо. Жирэмсэн эхийн тэтгэмжид шинээр 18 эхийг тэтгэмжид хамрууллаа. Байнгын асаргаа шаардлагатай ахмад настны тэтгэмжид шинээр 5 ахмадыг хамруулж, байнгын асаргаа шаардлагатай 9 ахмад настны тэтгэмжийн сунгалт, байнгын асаргаа шаардлагатай 1 хүүхдийн сунгалтыг хийж, аймагт хянуулан тэтгэмжийг олголоо. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хүрээнд Ахмад настан 3 иргэнд шүдний хөнгөлөлт 360000 төгрөг, Ахмад настан амралт, сувилалд сувилуулсан хөнгөлөлт 17 ахмад настанд 2573,6 мян/ төгрөгийг тус тус олгосон байна. Хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнд шүдний хөнгөлөлт 120,0 мян/ төгрөг олголоо. Мөн 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны 2 иргэнд тэтгэмж 2400,0 мян/төгрөг олгосон байна. Насны хишиг авах 59 иргэний 2018 оны бичиг баримтын баяжилт хийж, программд шивж жилд 2 удаа олгох тэтгэмжийг бүрэн олгож дуусгалаа. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 2018 оны 1-6-р сарын хугацаанд 6 өрхөд 2752000 төгрөгний хүнсний 10 нэр төрлийг бүтээгдхүүн олгуулж, хяналт тавин, сар бүр тайлан гарган хүргүүлээ.

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн** нэг "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжиж буй бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд Баянцогт 2-р багийн иргэн Л.Эрдэнэболорын 1 өрх буюу 2 иргэн 1 сая төгрөг, Шар-Ус баг, Рашаант тосгоны иргэн Ю.Энхсайхан, Д.Буянхишиг, М.Мөнхтуяагийн 3 өрхийн 4 иргэнийг 1 сая төгрөгний буцалтгүй санхүүгийн дэмжлэгт хамруулж өрхийн орлого нэмэгдүүлэх цаашдаа ногоо тариалах эх үүсвэрийг нь бий болгож улиралын ажлын байртай болоход дэмжиж ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Аж ахуй эрхлэлтийн сургалт” сум, тосгоны төвд энэ сарын 15-20-ны өдрүүдэд явагдаж 32 иргэн хамрагдаж гэрчилгээ авсан байна.

**Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын 6 дугаар сард 28975,0 мянган төгрөгний шимтгэлийн орлого оруулах төлөвлөгөөтэйгээс 28290,0 мянган төгрөг оруулж төлөвлөгөө 97,6 хувийн биелэлттэй байна. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг хамруулан шинээр 6 хүн буюу нийт 165 даатгуулагчаас 2310,4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 20 иргэдийг хамруулан 1071,1 мянган төгрөг орууллаа. Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт-369 хүнд-117127,1 мян\төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт-125 хүнд-32528,5мян\төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 26 хүнд 7091,1 мян\төгрөг, цэргийн өндөр насны тэтгэвэр 2 хүнд-1688,2, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1 хүн-404.5 мян\төгрөг нийт 158839,4 мян төгрөг тус тус тавьж олголоо. Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж 3 хүнд-407,7 мян\төг, Жирэмсэн амаржсаны тэтгэмж 2 хүнд-2953,8 мян\төг, ажилгүйдлийн тэтгэмжинд 5 хүнд 3361,5 мян\төгрөгийг хугацаанд нь олгосон байна. Ажилгүйдлийн даатгалын сангаас 3 иргэнд 863,6 мянган төгрөгийг хуваарийн дагуу харилцагч банкуудаар дамжуулан олголоо. 2018 оныг “Цахим үйлчилгээг хөгжүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан 6-р сарын 14-нд Төрийн банктай хамтран нийгмийн даатгалын тухай хуулийг сурталчлах, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сайн дурын даатгалын шимтгэлийг шуурхай төлүүлэх, Црау үйлчилгээ, зэрэг мэдээлэл сурталчилгааг хийж 30 гаруй иргэнийг хамруулан “Нийгмийн даатгал” апплейкшнийг 25 иргэн гар утсандаа суулгаж салбартай холбоотой мэдээллээ утаснаасаа авах боломжийг бүрдүүллээ. Мобайл банк, гялс банк үйлчилгээг 8 иргэний гар утсанд суулган сайн дурын даатгалын шимтгэлээ онлайнаар төлөх боломжийг бүрдүүллээ.

#### **ХОЁР. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

**Хөрөнгө оруулалт:** Энэ сард сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 2018 онд хийгдэхээр батлагдсан ажлуудаас Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах, Рашаант тосгонд сүү хөргүүрийн танк худалдан авах болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Цэцэрлэгийн дээвэр, хаалга засварын ажлын тендерийг зарлаж өнөөдрийн байдлаар Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах, цэцэрлэгийн дээвэр засварын ажлуудын гэрээ байгуулагдаж ажил нь эхлээд байна. Рашаант тосгонд сүү хөргүүрийн танк худалдан авах ажилд үнийн санал ирүүлсэн компани байхгүй тул дахин зарлагдана.

Аймгийн Засаг даргын эрх шилжүүлсэн зам, засвар тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг, Эмнэлгийн морг, гражийн засварын ажлуудын тендерийг зарласан боловч мөн үнийн санал ирүүлсэн компани байхгүй тул дахин зарлаад байна.

Ингэснээр энэ онд хийгдэхээр батлагдсан ажлуудыг 100 цахимаар зарлаж хялбаршуулсан цахимаар 4 ажил, уламжлалтаар 1 ажил хийгдэж байгаа юм.

**Төсөв санхүү:** Улсын төсөвт 5 сарын 31-ны байдлаар 7900,0 төлөвлөгөөнөөс 8415,5 оруулж 106,5%-тай биелэсэн, Аймгийн төлөвлөгөө 67405,0 байснаас 50071,0 оруулж 74,3%-тай байна. Сумын орлогын төлөвлөгөө ба биелэлтийг сараар харуулбал:

Татварын нэр төрлөөр харуулбал:

д/д	Татварын төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	5102,2	4446,0	87,1
2	Хувь хүнээс суутгасан	-	2238,3	-

	орлогын албан татвар			
3	Ургамал ашигласны төлбөр	2500,0	0	0
4	Ан амьтны нөөц ашигласн	331,0	0	0
5	Хөрөнгө борлуулсны орлого	416,5	460,0	110,4
6	Улсын тэмдэгтийн хураамж	2352,6	1293,9	55,0
7	Усны нөөц ашигласны төлбөр	643,8	0	0
8	Татварын бус хүү, торгуулийн орлого	3500,0	602,3	17,2
9	Нэр заагдаагүй бусад орлого	22327,8	8692,9	38,9
10	Галт зэвсгийн албан татвар	825,0	450,0	54,5
<b>Дүн</b>		<b>37997,9</b>	<b>18235,97</b>	<b>48,0</b>

Манай суманд үйл ажиллагаа явуулдаг 104 ААН, 20 гаруй иргэн байдаг бөгөөд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 ААН, 18 иргэн байдаг байна. Үүнээс төлбөрийн баримт олговол зохих 14 ААН, 1 иргэн буюу нийт 15 үйлчилгээний газар байна. Эдгээр 15 газар төлбөрийн баримт олгодог болгох, тогмолжуулах ажлын хүрээнд сар бүр татварын албаны хугацаатай албан шаардлага хүргүүлэн, ярилцлагын тэмдэглэл хийж ажилласанаар 4 ААН пос, терминал төхөөрөмж авч суурилуулан баримт олгодог болоод байна. Одоогийн байдлаар огт баримт хэвлэдэггүй 3 ААН, 1 иргэн байна. Энэ сарын 14-нд аймгийн Татварын хэлтсээс шалган туслах комисс ирж НӨАТУС-ын хэрэгжилтэд татварын хяналт шалгалт хийн зөрчлийн тухай хуулийн дагуу 3 иргэнд торгуулийн арга хэмжээ авсан байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмших болон газар эзэмших ашиглэх эрхтэй хуулийн этгээдийн эцсийн эзэмшигчийн бүртгэл явагдаж 6-р сарын 1-ний дотор маягтын дагуу бүртгэлийг хийлээ. Бүртгэлд 40 ААН байгууллагийн 250 гаруй газар бүртгэгдсэн.

## **ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

### **Боловсрол:**

**СӨБ:** 24-р цэцэрлэгээс хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр Зуны цэцэрлэг ажиллуулдаг бөгөөд тайлант сард төрийн албан хаагчдын ажлаа хэвийн явуулах хүүхэд асрах хүнгүйгээс ажлын байран дээрээ хүүхэдтэйгээ ирж өөрийн болон бусдын ажлын цагийг үр бүтээлгүй өнгөрөөх асуудал сургуулийн өмнөх боловсролын хичээлийн жил дууссаны дараа тулгардаг байсныг шийдвэрлэж сумын төвд “Монгол ви ти нет”ТББ-н Зуны цэцэрлэг, Рашаант тосгонд 24-р цэцэрлэгээс Зуны цэцэрлэг тус тус ажиллуулж нийт 40 гаруй хүүхэд хамрагдаж байна.

**ЕБ:**2017-2018 оны хичээлийн жилийн үйл ажиллагаа дуусч сургуулийн гадна тохижилтын ажлууд хийгдлээ. Элсэлтийн ерөнхий шалгалт аймгийн хэмжээнд энэ сарын 16-20-ны хооронд 5 өдөр явагдаж нийт 29 сурагч элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байна.

**Соёл урлаг:** Тайлант жилийн хугацаанд сумын Соёлын төвөөс уламжлалт соёлын арга хэмжээ болон тэмдэглэлт баяр зэрэг соёл урлагийн 30 арга хэмжээг зохион байгуулан нийт давхардсан тоогоор 2800 гаруй хүн, хүүхдэд хүрч үйлчлээд байна. Явуулын арга хэмжээг түлхүү зохион байгуулсанаар Рашаант тосгонд 15 удаа ажиллаад байна.

Байгууллагын ажилчдын ур чадварыг дээшлүүлэх үүднээс Номын санч орхон сумын номын санд 2 өдөр аймгийн нийтийн номын сантай хамтран бүсчилсэн сургалтыг зохион байгуулан хамтран ажиллалаа. Мөн ОНСТ ажилтанг аймгийн Нэгдсэн музейгээс зохион байгуулсан сургалтанд хамрууллаа.

МЭДЭЭ БИЧСЭН:

ТЭХЭЗ ДОТООД АЖИЛ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.МЭНД-АМАР

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Ш.ӨНӨРБАЯР